

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны бонин

27 дахь
жилдээ

№ 83 (2387)

1974 оны 11 дүгээр сарын 7

ПҮРЭВ

АУГАА ИХ ОКТЯБРЬИН 57 ЖИЛИЙН ОЙ

Аугаа их Октябрийн социалист их хувьсгалын 57 жилийн ойг Монголын ард түмэн, ЗСБНХУ, социалист хамтын нөхөрлөлийн орны хөдөлмөрчид, манай гаригийн бүх дэвшилт хүн төрөлхтөн ёслол төгс тэмдэглэж байна.

Яруу алдарт коммунист намаараа удирдуулсан Зөвлөлтийн олон үндэстэн ястаны баатарлаг ард түмэн одоогоос 57 жилийн тэртээд ажилчин ангийн дэлхий дахины түүхэн үүрэг, социалист хувьсгалын тухай Марксист—Ленинст онолын үнэн бодиттой болохыг нийгмийн хувьсгалт тэмцлийн практикаар баттай нотолж, хүн төрөлхтний түүхэнд шинэ эрин үеийг нээсэн билээ. Октябрийн хувьсгалын үр нөлөөгөөр социализм үүсэн бэхжиж дэлхийн систем болон урагш давшиж одоо манай гаригийн хүн амын гуравны нэг, газар нутгийн 26 хувийг хамарч дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 40 шахам хувийг бүтээж байна.

Октябрийн хувьсгалын дараа капиталист систем сүйрэн унаж тэр орон зайд 80 гаруй шинэ залуу улс бий болов. Октябрийн хувьсгалын үзэл санаагаар түүхийн бүтээлч тавцанд дэвшиж гарсан монголын ард түмэн ахар богино хугацаанд олон зуун жилийн хоцрогдлыг даван туулж ХАА—аж үйлдвэрийн социалист орон болсон юм.

Манай нам, энх тайванч гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлж, ах дүү социалист орнуудтай эв нэгдэл, хамтын ажиллагаагаа улам зузаатгаж дэлхийн шударга олон түмний тэмцэл хөдөлгөөнийг цаг үргэлж дэмжиж байдаг юм.

Олон улсын түүхэн ач холбогдол, нийгэм улс төрийн үлэмжийн их гавьяа бүхий энэ хувьсгалын ойн их баярыг монголын ард түмэн эх орноо капиталист бүс хөгжлийн замаар жолоодох түүхт үйл явдлыг шийдвэрлэсэн МАХН-ын III их хурал хуралдсан, БНМАУ-ынхаа тусгаар тогтнолыг тунхагласны хагас зуун жилийн ой, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид хүрэлцэн ирэхийн босгон дээр тэмдэглэж байгаа нь манай ард түмний улс төр хөдөлмөрийн идэвхийг өрнүүлээ.

Манай ард түмэн, МАХН-ын XVI их хурлын түүхэн шийдвэрийг биелүүлэх, эх орондоо социализмын бүрэн ялалтыг хангахад бүх ард түмний социалист уралдаанаар жигүүрлэн хөдөлмөрийн салбар бүхэнд гайхамшигт амжилт олж байна.

Ард түмнийхээ өрнүүлэн их хөдөлмөртэй мөр зэрэгцэн тус аймгийн бүтээлч хөдөлмөрчид Октябрийн хувьсгалын 57 жилийн ойд хөдөлмөрийн өрнүүлэн амжилтаар бэлэг барьж байна. Манай аймгийн хөдөлмөрчид Монгол—Зөвлөлтийн найрамдлын уламжлалт 23 дахь сарын ажлыг үзэл суртлын өндөр хэмжээнд явуулж, Зөвлөлтийн хүмүүсээс байнга суралцаж ялангуяа Курган мужтай шууд харилцаатай хамтран ажиллаж байгаа нь манай хоёр орны хэзээд эвдэршгүй ган бат найрамдлын нотолгоо болж байна.

ХАА-н хамт олон энэ жил 542,8 мянган төл хүлээн авч өнгөрсөн жилээс 100,6 мянгаар илүү төл бойжуулж 1974 оны мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэх бололцоо оллоо. Тариаланч хамт олон, олон мянган тонн ургац хурааж авлаа.

Бүх ард түмний социалист уралдаан эрчим далайцтай өрнөж, улс ардын аж ахуй, соёлын бүх салбарын төлөвлөгөөт зорилт амжилттай биелж байна.

Аймгийн аж үйлдвэрийн газрууд энэ оны эхний 10 сард 11,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж төлөвлөгөөгөө 115,2 хувь биелүүлэв. Хүнсний үйлдвэр жилийн төлөвлөгөөгөө биелүүлж, НААУ-ний газар, Ойн аж ахуйн модны үйлдвэр 30 хоногийн өмнө жилийн төлөвлөгөөгөө биелүүлэх боломжтой байна. Урьд олсон ололт амжилтаа улам бататгаж малын зүй бус хорогдлыг багасгаж, өвөлжилтийн бэлтгэлийг чанартай сайн хангаж, мал сүргээ тарган тавтай онд оруулах, ялангуяа нэг наст малын арчилгаа малагааг сайжруулах явдал манай аймгийн хөдөлмөрчдийн нэн чухал зорилт болж байна.

БАЯРЫН ХУРАЛ

Аугаа их Октябрийн социалист хувьсгалын 57 жилийн ойд зориулсан баярын хурал аймгийн Соёлын ордонд болов. Баярын хурлыг Зуунмод хотын намын хорооны нарийн бичгийн дарга Ш.Доржпалам нээж, Октябрийн социалист их хувьсгалын 57 жилийн ойд зориулсан илтгэлийг аймгийн АЛХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга М.Нямаа тавив. Дараа нь тус аймагт ажиллаж байгаа Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн ахлагч А.К.Лесков баяр хүргэж үг хэлэв.

Хурлын дараа Улсын симфони, Соёл эрдэнэ чуулгын тайлан тоглолт боллоо.

МАНЯЙ СУРВАЛЖЛАГЧ

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНЫ АЙЛЧЛАЛД

- 989,5 мянган төгрөгийн ашигтай
- Хагас жилийн ажил илүү хийнэ
- Сурлага хөдөлмөрийн 30 хоногийн цуваа

МАХН-ын III их хурал хуралдсан, БНМАУ-ыг тунхагласны түүхт хагас зуун жилийн ой, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай оронд зочлон ирэх баярт үйл явдлыг угтаж Хүнсний үйлдвэрийн хамт олон V таван жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлж байна.

Одоогийн байдлаар тус үйлдвэрийн ажилчин Осоржамбаа, Тогос нар V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 1 жил 6 сарын өмнө биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Мөн үйлдвэрийн тасаг салбарууд төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж байгаагийн дотор нарийн боовны тасаг, Эрдэнэсант, Архустын талхны салбарууд бусдаасаа давуу амжилттай ажиллаж байна.

1974 онд үйлдвэрлэх жилийн төлөвлөгөөг талхнаас 81 тоннйг илүү хийгээд байна. 1974 оны эхний 9 сарын төлөвлөгөөг үйлдвэрийн дүнгээр 123,8 хувиар биелүүлж хөдөлмөрийн бүтээмжийг 12,6 хувиар дээшлүүлэн, өөрийн өртгийг 6,2 хувиар хямдруулж, 989,5 мянган төгрөгийн ашигтай ажилласан юм.

Энэ ололтоо улам бататгаж жилийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл дээр нь 11 дүгээр сарын 16-ны өмнө биелүүлэхээр манай хамт олон



30 хоногийн өндөр бүтээлийн уралдаантай ажиллаж байна.

С.ЦЭГМЭД

Мөнгөнморьт сумын «Улаанбаатар» нэгдлийн үржил фермийн намын үүрийн нарийн бичгийн дарга Чойжилтэй уулзахад: —Манай фермийн төлөвлөгөөт ажил сайн байгаа, ялангуяа улсад тушаах сүүний төлөвлөгөөг олон мянган литрээр давуулах боломж оллоо.

Саальчдын маань олонх нь МХЗЭ-ийн гишүүд юм. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежневийг манай оронд айлчлан ирэх баярт өдөр, аймгийн ХЗЭ-ийн хорооны бүгд хурал угтаж өндөр бүтээлийн сарын уралдаантай ажиллаа гэв.

Фермийн эвлэлийн гишүүд энэ жилийн улсад тушаах сүүний төлөвлөгөөг 9 дүгээр сарын 15-ны байдлаар 114—165 хувиар биелүүлсний дотор саальчин Г.Бат, Д.Очирдулам, аймгийн ХЗЭ-ийн хорооны бүгд хурлын гишүүн Ц.Лувсандолгор нар V таван жилийн төлөвлөгөөг биелүүлээд үлдэж буй хугацаанд хагас жилийн ажил хийх амлалттай ажиллаж байна.

Тус фермд БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, саальчин Ичинхорлоо ажилладаг. Тэр эвлэлийн илгээлтээр ирсэн залуу

саальчдад ажлынхаа арга барилыг эзэмшүүлж V таван жилийн төлөвлөгөөг биелүүдсэн олон шавь нартай болжээ.

Л.ЭРХЭМБАЯР

Баянжаргалан сумын дунд сургуулийн захиргаа, пионерийн бүлгэмийн зөвлөл ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев манай оронд айлчлах гэж байгаа түүхэн үйл явдлыг угтаж сурлага хөдөлмөрийн 30 хоногийн цуваа зохион анги, бүлгүүдийн хооронд сурлагын уралдаан зарлаж ажиллаа.

Уралдаант хугацаанд ЗХУ болон Курган мужийг сурталчилсан булан, самбар гаргаж, анги бүр найрамдлын сэдэвт бүлэг салааны ажил явуулан, эцэг эх, пионер, баатарчуудад сонирхууллаа.

Энд Бадам багштай 5-ийн «А» ангийн «Мөнх найрамдал» сэдэвт бүлгийн ажил илүү сонирхолтой болов.

Сургуулийн захиргаа найрамдлын сарыг тохиолдуулан Курган мужийн сургууль, багш нартай харилцаа тогтоож тэдний туршлагаас суралцах ажил зохиож байна.

Мөн уралдааны өдрүүдэд Зөвлөлтийн хэвлэл захиалгын 7 хоног явуулж бүх багш, ажилчид 100 хувь хэвлэл захиаллаа.

Ж.БИНДЭРБЯА

ЗХУ-ЫН ӨГӨӨМӨРТУСЛАМЖ

ШИНЭ ФЕРМ АШИГЛАЛТАНД ОРЛОО

Монгол-Зөвлөлтийн уламжлалт найрамдлын 23 дахь сарын ажил, Октябрийн социалист их хувьсгалын 57 жилийн ой, ЗХУ КН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай эх оронд айлчлан ирэх баярт өдрийг угтсан хөдөлмөрийн ээлжид ЗХУ-ын өгөөмөр тусламжаар тус аймгийн Баянчандманд 400 үнээний фермийн иж бүрэн механикжсан барилга байгууламж баригдаж ашиглалтанд орлоо.

Уг барилга байгууламжийг хүлээн авах хөдөлмөрчдийн цуглаан октябрийн социалист их хувьсгалын 57 жилийн ойн босгон дээр Баянчандманий төвд болов.

Цуглааныг тус аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга М. Намаа уг хэлж нээсний дараа БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга С. Лувсангомбо, ЗСБНХУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын яамны зөвлөх М.П. Макаревич, ЗХУ-ын барилгын III трестийн дарга Н.С. Казаков, барилгачин Я. В. Борух, тус фермийн саальчин Ч. Цэвэлмаа нар уг хэлэв.

Цуглаанд ХАА-н яамны орлогч сайд, тус барилга байгууламжийг хүлээн авах БНМАУ-ын засгийн газрын комиссын дарга Ц. Дэмбэрэл, Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын

хорооны орлогч дарга Д. Жамбалдорж, МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Д. Моёобуу болон уг барилга байгууламжийг хүлээлгэн өгөх ЗХУ-ын засгийн газрын комиссын дарга В.Г. Зоз гарын зэрэг албаны хүмүүс оролцлоо.

Тус ферм 16 хэсэг барилга төхөөрөмжөөс бүрдэж буйн дотор үнээ, тугал, өсвөр үхрийн тохиллог сайхан байр, уурын зуух, мал, эмнэлэг, тракторын гарааш, 10 тоннын даацтай авто пүү, тус бүр 1000 тонн даршны багтаамжтай 3 зоорь, хоногт 2000 литр сүү хөргөж анхны боловсруулалт хийх чадалтай сүүн тасаг, цэвэр бохир усны систем, агааржуулах төхөөрөмж, 24 айлын сууц зэрэг үйлдвэрлэл, аж ахуйн өвч барилга байгууламж юм. Энэ ферм гадаадаас авч ирсэн сүүний хосломолонг шимтэй алатау, хар тарлан, шар тарлан, талын улаан үнээний үүлдэр сорих, нутагшил судлах, өөрийн орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон сүү үйлдвэрлэх технолог боловсруулах эрдэм шинжилгээний болон үйлдвэрлэл туршлагын бааз болох юм.

ЗХУ-ын хүч хөрөнгөөр баригдсан энэ шинэ ферм манай хоёр орны найрамдал хамтын ажиллагаа, ЗХУ-аас Монголын ард түмэнд сэтгэл харамгүй туслаж байдгийн бас нэг тод илрэл боллоо.

Ш. ЦЭРЭНДОО

АЯГАНЫ ХАРИУ ӨДӨРТӨӨ

Аугаа их октябрийн социалист хувьсгалын 25 жилийн ойг хүндэтгэн тэмдэглэж байсан 30 гаруй жилийн тэртээх түүхт өдрүүдийг өнөөдөр бид эргэн санаж байна.

Гучин нэгэн жилийн өмнөх өнөөдөр, манай ард түмэн, Зөвлөлтийн улаан армид туслах бэлэглэлийн III эшлоныг хуралдуулж фашистын германас, аугаа их социалист орны эсрэг хийсэн дээрмийн дайныг Зөвлөлтийн ард түмний ялгуулсан ялалтаар төгсгөхөд бүхий л талаар туслаж байсан юм. Энэ ариун үйлст монголын ард түмний оруулсан хувь нэмэр хоёр орны ард түмний түүхэнд алтан мөрүүд болон мөнхжжээ.

Амьдрал дахь эгэл нэгэн баримтыг иш татъя. «Бага сургуулийн ажилчид, баг сумын тэргүүлэгчид, анхны хоршооны ажилчид, агент суурин төлөөлөгчид, шуудан харилцааны өртөөчид, заводын хариуцлагатай ажилчид, захиргааг харсан зарлага, дотоод яамны төлөөлөгч, докторын газрын ажилчид, нам, эвлэлийн гишүүд, настан хөгшид хүүхдүүд» энэ ажилд эрвийх дэрийнхээрээ хамран оролцож 75,4 мянган төгрөг, 24,6 мянган төгрөгийн үнэ бүхий мал ба бусад зүйл бэлэг лэн энэ бүхнээ.

«Зөвлөлт улсын армийн, зүүн гарын нөхөр болж, баатар улаан армийн, баруун гарын багаж болж»-ын ерөөлийг дэвшүүдэг тус аймгийн Баян дэлгэр сумын 5 дугаар багийн ард Сүхдоржийн

Жанчивын бичиж байсан яруу сайхан шүлгийн мөрүүд түүний бичсэнээр «Сая орчим ардын маань санаа сэтгэлийн» илэрхийлэл болон хадгалагдсаар байгаа юм.

Элгэн халуун нөхөрлөлийг үнэлэн цэгнэсэн сүүн цагаан сэтгэлийнхээ дээж болгож III эшлонд булан төгрөгийн хандив нэмэрлэж байсан, энэ сумынхны өнөөдрийн амьдрал «Аяганы хариу өдөртөө» гэдэг ардын цэцэн үгийг өөрийн эрхгүй сагаг дуулна.

Манай ард түмэн ачийг тусгаар хариулдаг, хүний нийгмийн сэтгэлийг цэцэн цэлмэг үгээрээ ингэж илэрхийлдэг билээ.

Ухаан сэтгэхүйн сан хөмрөг нь хэмжихүүдээ нэн бэрх, ард түмнийхээ энэ үгийн гүн гүнзгий агуулгыг социалист эх орныхоо хөгжил дэвшил Монгол-Зөвлөлтийн ард түмний мөнх найрамдалтай холбон бодоход үнэхээр бишрэм, хүндэтгэм ажээ.

Тэсрэх бөмбөг, исгэрэх сумыг аюушшиггүй серж, шударга хүн төрөлхтний аз жаргалыг амь насаараа өмгөөлсөн, Зөвлөлтийн хүмүүсийн энх цагийн хүч хөдөлмөр, ариун хөдсний шимээр Баяндэлгэр сумын «Хэрлэн-баян» нэгдэл чухам л хаяа тэлэн цэцэглэж, эх орны маань ХАА-н нэгдлүүдийн хэтийн хөгжлийн бодит жишээ болж байна.

Энэ нэгдлийн 17,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үлэмжхэн хэсэг нь Зөвлөлтийн иргэдийн оюун ухаан, уран гаргаар сүндэрлэн боссон 400 гаруй хүүхэд суралцаж бай

гаа 8 жилийн дунд сургууль, 200-гаад үзэгчийн суудалтай сумын клубээс эхлээд орон сууц, соёл ахуйн өвч тоноглолгдсон барилга байгууламж, малын хашаа, хулаг, авто ба ХАА-н машин тоног төхөөрөмж болох нь илэрхий билээ.

Одоо Баяндэлгэрчүүд уугуул нутгийнхаа яруу найрагчийн бахархан дуулсанаар «Шувуун сааралынхаа хурдаар социалист шинэ амьдралаа зохиож байна».

«Хэрлэн-баян» нэгдэлд ЗХУ-ын өндөр мэргэжилтэй боловсон хүчин инженер, эдийн засагч, нягтлан бодогч, агрономч, малын их эмч, багш зэрэг 10 шахам хүн гар хумхилгүй хөдөлмөрлөж байна.

«Дийлдэшгүй их хүч нь ялагдашгүй найрамдалдаа байдаг» Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн барилдлагаа эгэл ардын маань амьдралд нь хүү шингээстэй байгаа нь үнэхээр сэтгэл баясаж, магнай тэнийн билээ.

Тулалдааны фронт, бүтээлч хөдөлмөрийн талбарт цус хөдсөөр гажнасан ариун найрамдалдаа чин үнэнч манай ард түмэн, түүний дотор тус аймгийн хөдөлмөрчид, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежнев манай оронд морилон ирэх өлзий учралт тэр өдрийг ард түмнийхээ итгэл хайрын илэрхийлэл болсон амтат цагаан сүүнийхээ дээжийг амсар дүүрэн мэлтэлзүүлж, ариун цэнхэр хадгаа өргөн барьсаар угтаж байна.

АДАВААНЯМ

ТҮҮХТ ГЭРЭЭ

1921 оны 11 дүгээр сард Зөвлөлт орос улсын засгийн газар ба Монголын засгийн газрын хооронд байгуулагдсан гэрээ нь Монголын ард түмний түүхэнд төдийгүй дэлхий дахины улс түмний хоорондын харилцаанд шинэ үеийг нээсэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Социализмын ууган оронтой тогтоосон интернационал найрамдал, бүх талын үр ашигтай хамтын ажиллагаа, түүний сэтгэл харамгүй өгөөмөр тусламж дэмжлэг нь Монголын ард түмний Ардын хувьсгалаар байдалд олсон эрх чөлөө, бүхий л ололт амжилтыг бэхжүүлэх, тус орны олон зуун жилийн хоцрогдлыг арилгаж, улмаар шинэ эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах ажлыг үүсгэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг түүхэн баримтууд нотлон харуулж байна.

1936 оны 3 дугаар сарын 12-нд манай хоёр ор

ны хооронд байгуулагдсан харилцаа туслах тухай протокол гэрээ нь ардын хувьсгалын ололтыг харийн түрэмгийлэгчдийн аюул заналаас хамгаалж ардчилсан хувьсгалын анхан шатны зорилтыг биелүүлэх, манай ард түмний энх түвшин аж төрөх, аюулгүй байдлыг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн ганбат найрамдал бол их бага улс орнуудын тэгш эрхт харилцааны анхны биелэл бөгөөд түүхийн олон удаагийн сорилтыг амжилттай даван туулж социализм коммунизм байгуулах явцад улам бүр зузааран бэхжсээр ирлээ.

БНМАУ-ын эрх чөлөө тусгаар тогтнолд халдан довтолсон японы империалистуудыг 1939 оны зун Халх голчин орчим бутцохисон нь Монгол-Зөвлөлтийн найрамдлын хүчин чадлын бас нэг баталгаа болсон юм.

Эх орны дайны үед МАХН, БНМАУ-ын Засгийн Газар, манай ард түмэн Зөвлөлтийн улаан армийн ялалтын төлөө чин үнэнч зогсож бүх хүчин чадлаараа тусалсан бөгөөд дайны төгсгөлд манай ардын арми, Зөвлөлтийн армийн мөр зэрэгцэн явж японы империалистуудын түрэмгийлэлийг бут цохисон билээ.

Дэлхийн II дайны дараах энх цагийн бүтээн байгуулалтын үед одоогоос 28 жилийн өмнө 1946 оны 2 дугаар сард манай хоёр улсын хооронд найрамдал, харилцан туслах тухай гэрээ, эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдсан нь тус хоёр орны бүх талын хамтын ажиллагааг зузаатгах, манай улсад социализмын үндсийг баттай тавьж улмаар социализм байгуулж дуусгах хөгжлийн шинэ үед дэвшин орох явдалд ихээхэн ач холбогдолтой болсон юм.

ЗХУ-ын тусламжтайгаар манай улсад аж үйлдвэр

түргэн хурдантай хөгжиж, түүний дотор уул уурхай, эрчим хүчний болон эх орны үйлдвэрийн бусад салбарууд бий болж барилгын үйлдвэр шинээр байгуулагдаж Зөвлөлтийн техник төхөөрөмжөөр тоноглолгдсон хөнгөн ба хүнсний үйлдвэрийн салбар түргэн хөгжиж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцааны түүхэнд олон тэмдэглэлт үйл явдлууд боллоо.

1965 оны 4 дүгээр сард Ю. Цэдэнбал тэргүүтэй манай нам засгийн төлөөлөгчид ЗХУ-д зочилж 1966 оны 1 дүгээр сард ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Брежнев манай оронд найрсгаар айлчилсан нь Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдалт харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд түүний гарамгай шинэ үйл явдал болсон юм. Энэ харилцан айлчлалын үеэр шинэчлэн байгуулсан гэрээ нь манай хоёр ард

түмний найрамдал хамтын ажиллагааны түүхэнд шинэ үеийг нээлээ.

Мөн 1970 оны 10 дугаар сард БНМАУ-ын нам, засгийн төлөөлөгчид ЗСБНХУ-д албан ёсны найрсгаар айлчлалт хийж хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааг ойрын жилүүдэд хөгжүүлэх асуудлыг хэлэлцэн тохиролцож V таван жилд манай улсын аж үйлдвэрийг цаашид хөгжүүлж түүний үр ашгийг дээшлүүлэх, ХАА-г хөгжүүлэх, түүний материал техникийн баазыг бэхжүүлэх, хөдөлмөрчдийн аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх чиглэлээр улам өргөжсөөр байна.

Манай хоёр орны хоорондын дээрх гэрээ хэлэлцээр нь БНМАУ-д социализм бүрэн байгуулахын төлөө улс орны эдийн засаг, соёлыг хөгжүүлэх үйлсэд асар их ач холбогдолтой төдийгүй Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааны тод илрэл мөн.

Р. БАЯРСАЙХАН

Статистикийн байгууллагын ойг тэмдэглэв

БНМАУ-д статистикийн байгууллага байгуулагдсаны хагас зуун жилийн ойд зориулсан Зуунмод хотын нам, улс, олонхийтийн байгууллага, хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн баярын хурал энэ сарын 2-нд аймгийн соёлын ордонд боллоо.

Байрын хурлыг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга Х. Дамдин нээж, аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ирүүлсэн баярын бичгийг статистикийн товчооны хамт олонд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. Даш дэмбэрэл уншиж гардуулла. Дараа нь БНМАУ-д статистикийн алба байгуулагдсаны 50 жилийн ойд зориулсан илтгэлийг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны статистикийн товчооны дарга Л. Нацагдорж хийв.

Дараа нь аймгийн статистикийн байгууллагын ахмад ажилтан Ө. Хаян-

хярваа, Жаргалант сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга Т. Баяр хүү нар баяр хүргэж үг хэлэв. БНМАУ-д статистикийн байгууллага байгуулагдсаны хагас зуун жилийн ойг угтаж зарласан уралдаанд улсад 3 дугаар байр эзэлсэн «Хэрлэн-баян» нэгдлийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Статистикийн Төв Газрын динлоо, 1000 төгрөгөөр, Батсүмбэрийн САА, аймгийн Хүнсний үйлдвэрийг Статистикийн төв газрын баярын бичгээр, БНМАУ-ын засгийн газрын хүндэт жуух бичгээр аймгийн АДХГ захиргааны Статистикийн товчооны дарга Л. Нацагдорж, «Статистикийн байгууллагын тэргүүний ажилтан» тэмдгээр Баянжаргалант сумын Д. Дамдинпүрэв, аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ажилтан Ө. Хаянхярваа, Хэрлэн-баян нэгдлийн Д. Жамсран нарыг, Статистикийн төв газрын сайшаалын үнэм-

лэхээр аймгийн АДХГ захиргааны статистикийн товчооны ахлах мэргэжилтэн Ц. Бямбаа, мэргэжилтэн Д. Аюуш, Барилга урсгалтын конторын норм зохиогч Дагва, Борнуур сумын Д. Алтангэрэл, Заамар сумын Ж. Чүлтэм нарыг, Улсын төлөвлөгөөний комиссын жуух бичгээр Мөлхөнморьт сумын орлогч дарга Ж. Очираймгийн АДХГ захиргааны баярын бичгээр статистикийн товчооны мэргэжилтэн С. Амарбат, Баян сумын Я. Минжид, Баян-өнжүүл сумын Ц. Жадамбаа, Лун сумын Д. Чойгончиг, Баянзүрх сумын Д. Бондон нарын 10 гаруй хүнийг, мөн аймгийн УЗ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо, Анчдын нийгэмлэгийн шагналаар Дондов, Д. Найдан, Ням-осор нарыг тус тус шагнасныг аймгийн АДХГ захиргааны дарга Ч. Даш дэмбэрэл гардуулла.

Хурлын дараа «Тамирын охин» гэдэг БНМАУ-ын уран сайхны шинэ кино гарав. Л. БАДАМЦЭРЭН

Байгуулагдсаны нь 20 жилийн ойд

БОРНУУРЫН САНГИЙН АЖ АХУЙ

Тус сангийн аж ахуй 213 мянган га нутагтай, 3200 хүн амтай бөгөөд нийслэл Улаанбаатар хотын хөдөлмөрчдийг сүү, ногоогоор хангах чиглэлээр үйлдвэрлэлээ явуулж байна.

Тус аж ахуй МАА-н 9, төмс ногоо, тэжээлийн 7 бригад, 26 мянган толгой малтай.

1960 оноос Зөвлөлийн Семинтал, Болгарын Софийн үйлдрийн үхрийг саалийн чиглэлээр цэвэрээр өсгөн нутгийн үхрийг эрлийзжүүлэн үржүүлж байна. Бүх үхрийн 61 хувь нь саалийн үнээ, 78 хувь нь цэвэр ба эрлийз юм.

Сангийн аж ахуй жилдээ 1,3—1,4 сая литр сүү, 3800 гаруй тонн төмс, 6000 тонн нарийн ногоо улсад тушаадаг. Тус сангийн аж ахуйн нийт бэлчээр усжуулагдаж, бүх мал хоёр ээлжийн хашаагаар хангагдав.

Одоо тус сангийн аж ахуйд дээд, дунд боловсролтой тусгай мэргэжлийн боловсон хүчин 104, мэргэжилтэн ажилчид 300 гаруй ажиллаж олон арван тэргүүний хүмүүс төрөн гарлаа.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, ногоочин С. Бадамсүрэн, Улсын аварга ногоочин, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Д. Цэрмаа, Улсын аварга комбайнч Д. Гантоого, Г. Чунаг, Улсын аварга ногоочин Чинэцэрэн, Улсын аварга тракторчин Н. Жамц нарын зэрэг улс аймгийн аварга 10 гаруй, сумын үйлдвэрлэлийн аваргууд олон арван төрж түүний тоо жил тутам олширсаар байна.

САА-н төвд 8 жилийн дунд сургууль, хүн, мал эмнэлэг, ясли, цэцэрлэг, зочид буудал, халуун ус, 160 гаруй айлын орон сууц зэрэг соёл үйлчлэлийн олон газар ажилдаж байна.

Тус сангийн аж ахуйн 10 хүн тутмаас 4 нь ямар нэгэн сургуульд суралцаж нэг их эмчид 459 хүн ноогдож хүн амын цэвэр өсөлт эрс нэмэгдэв.

Сумын өрх айл бүхэн радиотой болж өрх тутамд гадаад тогтоодын тогтмол сонин хэвлэл 4 ноогдож байна.

Тус сангийн аж ахуй жилдээ 14 сая төгрөгийн бүтээгдэхүүн гаргаж 12 сая төгрөгийн борлуулалт хийж 1,2—5 сая төгрөгийн ашигтай ажилладаг орчин үеийн томоохон аж ахуй болох хөгжлөө.

П.ЖАНЧИН

Д. ЧҮЛГЭМ

ХУДАЛДААНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛЧДЫН II ЗӨВЛӨЛГӨӨН

Аймгийн худалдаа бэлтгэлийн байгууллагын тэргүүний ажилчдын II зөвлөлгөөн Зуунмод хотод сайхан боллоо.

Анхдугаар зөвлөлгөөнөөс хойш 11 жилийн дараа хийж байгаа энэ зөвлөлгөөн нь худалдаа үйлчилгээнд гарсан тэргүүн туршлага, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх судалж сурталчлах, хөдөлмөрчдийг худалдаагаар хөнгөн гавшгай, соёлч хичлэхэд чиглэгдлээ.

Ажил үйлсээрээ шалгарсан худалдагч, агент, тогооч, зөөгч, бэлтгэлийн эрхлэгч, манач, барааны нярав зэрэг 62 сайчууд зөвлөлгөөнд шалгарч оролдов.

Тус зөвлөлгөөнд аймгийн худалдаа бэлтгэлийн удирдах газрын дарга Д. Гончиг «Хөдөлмөр соёлын өсөн сарын аяны дунд худалдаа бэлтгэлийн байгууллагуудын зорилт» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Зөвлөлгөөн дээр Батсүмбэрийн САА-н ХБА-ийн дарга О. Дармаа, Алтанбулаг сумын худалдагч Даариймаа, Өндөрширээт сумын ХБА-ийн ня-бо Г.Ба

р нарын 20 гаруй хүн хэлж ажлынхаа туршлагаас ярилаа. Аймгийн ХБ-ийн байгууллагууд зөвлөлгөөн угтан зарласан хөдөлмөр соёлын өсөн сарын аяндаа хөдөлмөрийн сайхан амжилт гаргасан байна. Тухайлбал энэ оны эхний сард 5,9 сая гаруй төгрөгийн бараа, ном, нийтийн хоол борлуулсан худалдаж төлөвөгөөт үүргээ 100—165,5 хувь биелүүллээ.

Аймгийн хэмжээгээр таван төрлийн ноос бэлт

гэх хөдөлмөрийн төлөвлөгөөг 5,3 хувь давуулж, бэлтгэлийн 25 нэр төрлийн эхний өсөн сарын төлөвлөгөөг 100—192 хувь биелүүлж ноднигийнхоос ахиц амжилт гаргажээ.

Мөн 3 дугаар улирлын балансаар бараа бэлтгэл, нийтийн хоолны гүйлгээнд оногдох зардалыг 0,96—5,27 хувь хэмнэж олох ашгийн төлөвлөгөөг 54,2 хувь давуулжээ.

Хөдөлмөр соёлын өсөн сарын аянд 700 ажилчин үүрэг авч ажиллаад амласнаа хэрэгжүүлэв.

Худалдаа үйлчилгээнд олон тооны тэргүүн туршлага нэвтэрснийг тус зөвлөлгөөн анхааралтай хэлэлцэв. БНМАУ-ын худалдааны гавъяат ажилтан, мастер тогооч Б. Даш зэвэг нийтийн хоолны газар 26 жил ажиллахдаа 3,5 сая таваг амт чанар сайтай хоолоор хөдөлмөрчин олноо үйлчилж, 5,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний дээр үйлдвэрлэл үйлчилгээний хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хоолонд өнгө үзэмж чимэглэл хийгдэх зориулсан 50 гаруй багаж хэрэгслийг санаачлан үйлдвэрлэлд нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгсөн байна. Эдгээр багаж нь Дархан, Сэлэнгийн бүсийн «ШБОС-73» үзэсгэлэнд II байр эзэлжээ.

Зуунмод гуанзны хамт олон хоолны чанарыг сайжруулахын тулд өдөр тутам хийж байгаа хоолонд чанарын үзүүлэлтийн дэвтэр хөтөлж, хөдөлмөрчдийн санал авах, байгууллага хамт олныг урьж үйлчлэх, урьдчилж захиалга авах, баяр ёсло-

лын нэрэмжит үйлчилгээг зохиох зэргээр үйлчилгээний дэвшилтэт шинэ хэлбэрийг ажилдаа нэвтрүүлсэн байна.

Худалдагчаар 25 жил ажиллаж байгаа Зуунмод хотын их дэлгүүрийн худалдагч, аймгийн аварга Л. Долгор хамтын тооцоотой тасаг байгуулан ажиллаж олон хүнд нэг зэрэг шуурхай үйлчлэх хүрээг өргөтгөлөө.

Сэргэлэн сумын ХБА-ийн бэлтгэлийн эрхлэгч М. Дэмбэрэлпүрэв бэлтгэлийн зүйлийн анхан шатны чанарын тордолт хамгаалалтын талаар хөдөлмөрчдийн дунд үзүүлэх сургууль хийх, зурагт үзүүлэлтээр сурталчлах, бэлтгэлийн зүйлд учирч болох гэмтлийн шалтгааныг тайлбарлан түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч нэг агентын хүлээн авсан бэлтгэлийн зүйлийг нөгөө агентаар дугааруулан шалгах зэрэг ажлыг зохиондог тус сум чанар сайтай бэлтгэлийн зүйл нийлүүлдэг боллоо. Баянзүрх сумын агент аймгийн 2 удаагийн аварга Доржготов 15 жил ажиллахдаа өөрийн хариуцсан өрх, хүн бүрт хүрч үйлчлэхийн тулд нарийн график гарган түүнийгээ мөрдлөг болгон айл бүрийн хүн ам, мөнгөн орлого, сар тутам хүнсэнд хэрэглэгддэг хэрэгцээт барааны тоо, хэмжээ бэлэн хувцасны өмсгөл хэмжээг судлан гаргаж түүнд тохируулан үйлчилдгээ сар, улирлын төлөвлөгөөг тогтмол биелүүлдэг байна.

Худалдаа бэлтгэлийн байгууллагын тэргүүний ажилчдын II зөвлөлгөөн

Яруу найргийн хуудас БУГЫН ДУУ

Шаргал намрын ойн дундаа
Зоргол олон сүрэг дундаа
Аргил сайхан эврээн өргөөд
Оргил хангайн хангал буга
Хөшүүн сэтгэлийг сүжрэн байж
Хөөмийлөнхөн юуг дуудна вэ
Хөглийнхөн хүрэнгэгч уул тайгын
Хөхөмдөгрен зулрагч манан дундаас
Өдий насалсан он жилий минь
Өнгөт намрыг буга дуудаж байна.
Уралдааны хүлгээс газар харахад
Уяхан цэцгүүд ирвэлээд үлддэг шиг
Альхан завандаа туулав даа гэмээр
Амьдралын дурьдатгал сэргээж байна.

Хатан дуугаар урамдсан
Халтар халиун буга минь
Хаа эртний танил дуу чинь
Хамаг үсий минь цантуулсан ч гэлээ
Нас насны минь намрыг дуудсан
Найртай эгшиг чинь уянгатай сайхнаа
Намар намрын будан дундаас
Намтар түүхий минь тодрууланхан
Шинэ халуун тэмүүллээр
Шинэчилж зүрхий минь догдлоов
Аялгуу дуутай чинь ирэх жилүүдийг
Амжиж алхаагүй шинэ замуудыг
Амьдрал бялхсан энэ л хорвоодоо
Амьдын жаргалаар туулах гэж
Ахин ахин ирэх намруудад
Аялгуу дууг чинь сонсохыг хүсдэгээ.

Ш. ЦЭРЭНДОО

Дэл хэцийн дунд улаа бутраан жаргах
Дэлхийн шаргал нарны мөнхийн дагуул адил
Дэлгэр талын хаяа руу хаван шингэх түүнийг
Дээвэрт гэртээ авчирья гэж алган нэхэх ижил
Нэл сайхан шаргалтаж талын наран жаргахуй

Нэгэн морьтон яарч дарцаглуулан одов
Гүүн ээлний дэргэд цагаан тоосоо орхиж
Гүвээ толгойн цаагуур шоволзон далд оров
Сайхан нарны мандах хорвоо дэлхийн өглөөг
Саяын энэ морьтон холоос авч ирнэ

Дэлхийн нарыг хөөж яаран яаран давхснаас
Дэлт сайхан хүлэг нь сульдаж ирсэн юм шиг
Дэнжийн хотонд ирэнгээ унасан морио юүлж
Товруу цагаан гэрээс үдшээр гарсан хархүү
Тоонын хуруу бөгжлөх нартай цуг ирнэ.

Д. ЦООДОЛ

Унийн толгойг наран бөгжлөж
Өглөөн сэрүү бүдээ оргив
Үүрийн талд адуу зүүрмэглэж
Өвсөн шүүдэр алтран гялазав

Далай шиг тал нүднээ алсран
Далдхан увидас сэтгэл сэргээв
Алтан шашир ургацаа наминаж
Аглагхан тал тосон золгов

Аяны замын дөрөө мулталж
Аавын гэрийн үүдийг татав
Аяншсан хацрыг эцэг минь үнсэж
Ажил үйлий минь лавлан асуув

Хунгийн хүзүү шиг гараа сунгаж
Хултай айраг ээж минь барив
Зулай цоорхой нялзрайд санаж
Цагаан буурал үсий минь илбэв

Б. ЦЭРЭНДАШ

Энх амгалангийн дуу

Сэвлэг салхи үнсэн илбээд
Сэтгэл санаа уужим байна
Цээлийн нууранд шувууд чуулаад
Цэнгэлийн өглөө амгалан байна

Намираа бороо наран хослоод
Найман зүгтээ цацран байна
Настан буурлууд жарган цэнгээд
Нарлаг өдрүүд амгалан байна.

Үүлгүй тэнгэрт саран гийгээд
Үзэмж байгаль тодхон байна
Үрийн баясаанд эхийн сэтгэл
Үдшийн гэгээнд амгалан байна

Нутаг усны цэнгэг сайханд
Нүүдлийн шувууд тайван байна
Түмэн олны үйлс өөдөө
Төрсөн нутаг амгалан байна

П. ОЧИРБАТ

Хүүхдийн дуу

Хүүхэд хүүхэд
Хүний жаргалыг дуулна
Хүний жаргалыг дуулаад
Хорвоо ертөнцийг уяраана

Алихан багачууд
Агуу орноо дуулна
Бахтай дууны эгшгэнд нь
Баясгалант ирээдүй нь тодорно

Ш. ДИНАМ

УЛААНБААТАР

Туул голын устай
Уртаа үзээд тэлсэн
Уул уулын оргилтой
Өндрөө жишээд сүмбэрлэсэн

Азийн цагаан дагина
Улаанбаатар хот минь
Ард Монгол улсын минь
Алдарт сайхан нийслэл

Таван тивийн хотуудтай
Тайван энхийн холбоотой
Тавин жилийн хөгжилдөө
Гайхам бүтээлийн унараатай

Азийн цагаан дагина
Улаанбаатар хот минь
Аз жаргалт олны минь
Амин хайртай нийслэл

Х. ЦЭВЭГМЭД



Зөвлөлт Социалист автономит Халимаг улс Каспийн тэнгэсийн эрэг хавийн 3 сая гаруй га хар газрыг малын бэлчээр болгон ашигладаг байна. Энэ нутаг 3 дахь жилдээ «Калмык» гэдэг нарийн ноост хонины аж ахуйн хөгжлийн гол район болж байгаа аж. Уг аж ахуйн гэрээний үйлдвэр хонио үржүүлдэг «Хар газар» хэмээх завод бүтээгдэхүүнээ шилжүүлдэг байна. Энэ үйлдрийн хонь өндөр ашиг шимтэй учир гуравхан жилийн дотор 1 сая 700 мянган рублийн ашгийг уг заводад оруулжээ. ЗУРАГ ДЭЭР: Социалист хөдөлмөрийн баатар, хоньчин Е. Лукшанов, К. Лукбанов нартай ухуулагч багш К. А. Рсаев (дундах нь) уулзан ярилцаж байна. Доод хэсэгт нь: Хамгийн өндөр жин татсан «Шуба» хэмээх аварга хонь.

ТАСС-ын гэрэл зураг

ТУРШЛАГАТАЙ МАСТЕР

(Тэмдэглэл)

Буянт ухаа улирлын аяс даган шаргалтан унартаж хөл хөдөлгөөн ихтэй байв. Ажилчны энэ хотхонд авсаархан барьсан хашаа, байшин цэцгээр цагаан гэр ирийж харагдана. Энд уг удмаараа гэр бүлээрээ ажилчин байж амжилт үйлсээрээ олондоо алдаршсан хэдэн зуун ажилчны бүлийнхөн байдаг.

Тэдний нэг нь гутлын үйлдвэрийн мастер Чанровын Дамбынх юм.

Тэрээр одоо зуугийн ихэнхийг насалж нийслэл хотдоо 40 жил амьдрахдаа гутлын үйлдвэрт 30

жил ажилласан жирийн нэгэн иргэн. Эднийх 7 хүүхэдтэй. Энхэр Ханд автобусанд зон олондоо үйлчилж явахад Дамба гуай далсан заншлаар гутлын үйлдвэрийн 134 дүгээр тасагт мастерын ажилдаа хичээнгүйлж байдаг. Мастер хүн яаж ажиллавал амжилт олох вэ? гэдэг асуултанд хариу өгсөн юм.

—Мастер хүний ажил сайн байх нь ажилчдын хөдөлмөрийн сахилга бат, машин техник сааталгүй ажиллах, материал хангамж сайн байх, бүтээгдэхүүнийг тогтмол сайн

чанартай байлгахын тулд технологи ажиллагааг ягштад баримтлах, ажлын эмх цэгц эдгээрээс шалтгаална. Эдгээрийг хангавал улсын болон үйлдвэрийн өмнө хүлээсэн үүрэг, зорилтоо хангаж чадна. Иймээс мастер хүн хэзээ ямагт хүнтэй уйгагүй ажиллаж хамт олны хүчийг жигд зөв зохион байгуулан ажиллаж чадвал амжилт олж болно. Мастер хүн дамжлага нэг бүрийг ажлын цагт хяналтаасаа гаргахгүй байхын зэрэгцээ ажилчин бүртэй ажиллах нь чухал юм.

Миний хувьд бол 25 жил мастер хийсэн. Энэ хугацаанд цех тасгийн дэргэдэх нам, эвлэл, ҮЭ-ийн байгууллагын байн-

гын удирдлагаар 7 хоног, сар, улирал бүр нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажилчдын дунд соёл хүмүүжлийн ажлыг чанартай зохион байгуулж, үйлдвэрлэлийн техник технологийг ямагт жигд хэвийн байлгахдаа ажлаа чиглүүлэн явуулдаг. Ажилчин бүрийн ажлыг богино хугацаанд тодорхой дүгнэж амжилтыг урамшилтай холбох нь их үр дүн өгдөг.

Хэрэв алдаа дутагдал гарвал дор нь засах ажил зохиодог. Тэгэхдээ мастер хүн өөрөө технологи ажиллагааг тун сайн мэддэг байх шаардлагатай.

Бас ажилчинд тавих

шаардлагыг ямагт өндөр байлгаж хувь хүний тухайн араншинд тохируулж ажиллах хэлбэрээ зөв олох нь сайн юм шиг санагддаг. Хүн нэг бүртэй, дамжлага бүхэнд дээр хүртэж ажиллахад тасгийн мастер хүн тун их чармайлт самбаа гаргах хэрэгтэй гэв.

Гутлын үйлдвэр 6 том тасаг, 1000 шахам ажилчинтай бөгөөд энэ үйлдвэрийн бүх тасагт Дамба гуай мастераар ажиллажээ. Ингээд бодохоор Дамба гуайн нөр их хөдөлмөр оролдсон гутал, ботник өмссөн хүн олон арван мянгад хүрээ бий.

О. РЭНЧИЙ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ